

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН “УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ”  
НИЙГЭМЛЭГ, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН “СӨҮЛ МЕТРО”  
КОМПАНИ ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын “Сөүл метро” компани /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нь,

харилцан хүндэтгэл, нэгдмэл сонирхлын зарчимд тулгуурлан,

Талуудын урт хугацааны эдийн засгийн хөгжлийн зорилтод хүрэхэд чиглэсэн нийтийн тээврийн салбар дахь эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэхийг эрмэлзэн,

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын “Сөүл метро” компани хооронд хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг дараах нөхцөлтэйгөөр байгуулахаар харилцан тохиролцов. Үүнд:

**1 дүгээр зүйл  
Зорилго**

Хамтын ажиллагааны зорилгод:

1. Нийтийн тээврийн салбарт мэдээлэл, техник технологи, туршлага хуваалцах замаар Талуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хөгжүүлэх;
2. Талууд хоорондын нийтийн тээврийн салбарын төлөвлөлт, менежмент, чадавхийг бэхжүүлэх, зөвлөх үйлчилгээ, судалгаа болон сургалт солилцооны таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

**2 дугаар зүйл  
Хамтын ажиллагааны хүрээ**

Хамтын ажиллагааны хүрээнд дараах чиглэлүүдийг хамруулна. Үүнд:

1. Нийтийн тээврийн салбарын хөгжлийг хөхүүлэн дэмжиж, харилцан дэмжлэг үзүүлэх;
2. Нийтийн тээврийн салбарт харилцан мэдээлэл, туршлага, нөү-хауг хуваалцах замаар эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
3. Нийтийн тээврийн салбарт сургалт, судалгаа явуулах, туршлага солилцох, мөн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх,

4. Нийтийн тээврийн салбарын үйлчилгээний менежмент, хэрэглэгчийн менежментийг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, туршлага судлах,

5. Төмөр замын нийтийн тээвэр дэх, үйлчилгээ, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр туршлага солилцох.

### **3 дугаар зүйл Хамтын ажиллагааны хэлбэр**

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг (цаашид “Санамж бичиг” гэх)-ийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагаа нь дараах хэлбэрүүдтэй байж болно.Үүнд:

1. Нийтийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх,

2. Нийтийн тээврийн чиглэлээр тэргүүн туршлага, технологийн дэвшлийг хуваалцах, түүнчлэн холбогдох мэдээллийг солилцох,

3. Нийтийн тээврийн чиглэлээр мэргэжилтэн, судлаач, инженер, техникийн ажилтан сургах, солилцох,

4. Хоёр улс болон бусад улсад нийтийн тээврийн төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтран оролцох боломжийг судлах,

5. Нийтийн тээврийн салбарын хөгжлийн стратеги, нөү-хауг хуваалцах зорилгоор хамтарсан уулзалт, техникийн семинар, аж үйлдвэрийн технологийн хөтөлбөр, үзэсгэлэн яармаг зэрэг арга хэмжээг хамтран зохион байгуулах, оролцохыг дэмжих.

### **4 дугаар зүйл Хэрэгжилтийн хүрээ**

1. Энэхүү санамж бичиг нь 4.5 дугаар зүйлд зааснаас бусад үед (Нууцыг хадгалах) Талуудад ямар нэгэн хууль зүйн үүрэг оногдуулахгүй.

2. Талууд тусгайлсан гэрээ, хэлэлцээр байгуулаагүй бол бол энэхүү Санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагаанаас үүдэн гарах аливаа зардлыг өөрсдөө хариуцна.

3. Талууд хамтын ажиллагааны арга хэлбэрийг хэлэлцэх, мэдээлэл солилцох зорилгоор хугацаа болон газрыг харилцан тохиролцож, хамтарсан уулзалт зохион байгуулж болно.

4. Аливаа оюуны өмчийн эрх нь талуудын хооронд харилцан бичгээр зөвшилцэнэ.

5. Талууд санамж бичгийн дагуу хамтын ажиллагаатай холбогдуулан нөгөө талаас олж авсан мэдлэг, мэдээллийн нууцыг хадгалахыг зөвшөөрсөн болно.

**5 дугаар зүйл**  
**Зөвлөлдөх**

1. Талууд энэхүү Санамж бичгийн зүйл заалтуудтай холбоотой аливаа асуудлаар нөгөө талын хүсэлтийн дагуу зөвлөгөөн хийж болох бөгөөд хамтын ажиллагааны явцад гарч болзошгүй хүндрэл, үл ойлголцлын асуудлыг харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны үндсэн дээр шийдвэрлэнэ.

**6 дугаар зүйл**  
**Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү Санамж бичиг нь Талууд түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд шинээр Санамж бичиг байгуулах хуртэл хүчинтэй байна.

Энэхүү Санамж бичгийг ..... хотноо 2019 оны .... дугаар сарын ....-ны өдөр монгол, солонгос,англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй. Санамж бичгийн заалтыг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх бичвэрийг баримтална.

МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ  
НИЙЛҮҮЛСЭН “УЛААНБААТАР  
ТӨМӨР ЗАМ” НИЙГЭМЛЭГИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС  
УЛСЫН “СӨҮЛ МЕТРО”  
КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ: